

УСНЫ КОМПАКТ

Улаанбаатар хотын
УСУГ-ын хөрөнгийн
менежментийг
сайжруулах техникийн
туслалцаа үзүүлнэ



Энэ тухай 4-р нүүрээс уншина уу

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн
гадна талбайн ажлын гүйцэтгэл
96.80%-д хүрлээ.

Улаанбаатар хотын унд ахуйн усан
дахь зэвийг арилгах төлөвлөгөө,
зөвлөмж боловсруулна.

Нидерландын ээлжит сургалтад
16 инженер, техникийн ажилтан
хамрагдлаа.



Үйлдвэрийн хаягдал усыг
цэвэрлэхтэй холбоотой 16 цуврал
вебинарыг бэлтгэв

ВЕБИНАР ЦУВРАЛ-1

ХАЯГ ДАЛ УСНЫ БОХИРДЛЫН
АЧААЛЛЫГ ТОДОРХОЙЛОХ АРГА,
АРГАЧЛАЛ

Үйлдвэрийн хаягдал усыг
цэвэрлэхтэй холбоотой харилцаанд
оролцогч төрийн байгууллага, хувийн
хэвшил, мэргэжлийн болон сургалтын
байгууллагууд, түүнчлэн иргэд олон
нийтэд зориулсан цуврал вебинарыг
танилцуулж байна.



Үргэлжлэл 5-р нүүрт

Хаягдал ус дахин боловсруулах төслийн захирал

Д.Мэндсайхан: Эрчим хүчний
үйлдвэрлэлд дахин боловсруулсан
ус ашигласнаар жилд 18 сая шоо
метр гүний ус хэмнэнэ



Гүний усыг үйлдвэрлэлийн
зориулалтаар ашиглах нь хайран
бөгөөд хэт үрэлгэн хэрэг. Энэ
төслөөрөө бид эрчим хүч үйлдвэрлэлд
буюу Улаанбаатар хотын дулааны
цахилгаан станцуудад ашигладаг гүний
усны хэрэглээг дахин боловсруулсан
усаар орлуулна. Өөрөөр хэлбэл,
Усны Комплексын хүрээнд дахин
боловсруулсан усыг үйлдвэрлэлийн
зориулалтаар илүү далайцтайгаар
ашиглах анхны туршлагыг эрчим
хүчний салбарт нэвтрүүлэх гэж байна.

Монгол Улсын Засгийн газар, АНУ-
ын Мянганы сорилтын корпорацийн
хооронд байгуулсан Мянганы
сорилтын II Компакт гэрээ буюу Усны
Компактаар Улаанбаатар хотын урт
хугацааны ус хангамжийн асуудлыг
шийдвэрлэхээр хэрэгжүүлж буй гурван
томоохон төслийн нэг Хаягдал ус
дахин боловсруулах төсөл. Уг төсөл
Улаанбаатар хотын, цаашлаад Монгол
Улсын нийгэм, эдийн засагт ямар
нөлөөтэйг илэрхийлэх цөөн хэдэн тоон
мэдээллийг дурдъя.

Үргэлжлэл 3-р нүүрт



Үйлдвэрийн хаягдал усыг
урьдчилан цэвэрлэхийн ач
холбогдлыг таниулна

Үргэлжлэл 3-р нүүрт

ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ


Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим шоо метрээр нэмэгдэх юм.

Үйлдвэрийн гадна талбайн ажлын гүйцэтгэл 96.8 хувьд хүрээд байна



Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "МАПА Иншаат Тиажарет" ХХК-ийн барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 2025 оны нэгдүгээр сарын 31-ний байдлаар 93.3%-д хүрээд байна. Үүнээс үйлдвэрийн гадна талбайн ажил 96.8%-ийн гүйцэтгэлтэй байна.

Ус дамжуулах шугам хоолойн угсралтын ажил 79.9% байна



"МАПА Иншаат ве Тижарет" компани нэмэлт ажлын даалгаврын хүрээнд нийт 13 км ус дамжуулах шугам хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд нийт гүйцэтгэл 79.9%-тай явж байна.

100% Түүхий ус дамжуулах хос шугамын угсралтын ажил

66.5% Биокомбинатын цуглуулах шугамын ажил

85.9% Дамжуулах шугамын ажил

84.5% Цэвэршүүлсэн ус дамжуулах шугамын ажил

"Баран групп"-ийн гүйцэтгэж буй нийт ажлын гүйцэтгэл 68.5%

Шугам хоолойн сүвлэгээний ажлыг "IYEZ" ХХК болон "Эрдэнэдрилинг" хийж гүйцэтгэж байгаа бөгөөд сүвлэгээний бэлтгэл ажил болох босоо амны барилга угсралтыг "Монгол менежментийн төв" ХХК, "Бодь пропертийз" гүйцэтгэж байна. Цахилгаан болон механикийн угсралтын ажлыг БНТУ-ын "ҮЕО" компаниар тус тус гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

"Баран групп"-ийн гүйцэтгэж буй нийт ажлын гүйцэтгэл 2025 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар 68.5%-тай байна.

43.1%

Биокомбинатын эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил

37.6%

Шувуун эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил

93.4%

Шувуун дамжуулах шугам хоолойн болон хаалтын худаг

44.1%

Төслийн нийт сүвлэгээний ажил

56.0%

Шилэн кабель

Товчхон

Шувуун фабрик эх үүсвэрийн талбайд 6.4 км ус цуглуулах, 16 км ус дамжуулах шугам хоолойг тус тус суурилуулаад байна. Үүнээс нийт 12.3 км шугам хоолойд гидравлик туршилт хийсэн.

Хаягдал ус зайлуулах шугам хоолойн суурилуулалтын ажлын хүрээнд 1073 метр талбайд газар шорооны ажлыг хийж, 1067 метр урт шугам хоолойн угсралт хийлээ.

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ("ХУДБҮ") болон дахин боловсруулсан усыг "ДЦС-3", "ДЦС-4" ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжснээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.

Хаягдал ус дахин боловсруулах төслийн захирал

Д.Мэндсайхан: Эрчим хүчний үйлдвэрлэлд дахин боловсруулсан ус ашигласнаар жилд 18 сая шоо метр гүний ус хэмнэнэ



Түрүүч нь 1-р нүүрт

Нэгдүгээрт, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны байдлаар 70.4 их наяд төгрөгт хүрснээс Улаанбаатар хотын эдийн засаг ойролцоогоор 46.9 их наяд төгрөг буюу 66.7 хувийг нь бүрдүүлсэн байгаа. Хоёрт, Монгол Улсын нийт газар нутгийн 0.3 хувь буюу 4,704.4 км² талбайд нийт хүн амын 50 орчим хувь нь оршин сууж байна. Гуравт, Монгол Улсад бүртгэлтэй 200 мянган аж ахуйн нэгжийн 150 мянга буюу 75 хувь нь Улаанбаатар хотод байна. Үүнээс 118 мянга орчим аж ахуйн нэгж, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа нь Монгол Улсын хэмжээнд ажиллаж буй нийт аж ахуйн нэгжийн 70 гаруй хувийг бүрдүүлж байна гэж Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд дурдсан байна.

Товчхон хэлбэл, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн төвлөрөл Улаанбаатар хотод байна гэсэн үг. Ер нь нийслэл хотын асуудал бол Монгол Улсын асуудал болсон байна гэхихэд нэг их буруудахгүй байх.

Энэ том тоонуудыг Компакт гэрээ боловсруулахын урьдач судалгаа хийсэн 2017 онтой харьцуулахад сүүлийн 7-8 жилийн дотор Монгол Улсын ДНБ 2.5 дахин /28-аас 70.4 их наяд/, Улаанбаатар хотын ДНБ гурав

дахин /15.7-аас 46.9 их наяд/ өсжээ. Харин хүн ам 1.4-өөс 1.6 сая болж өссөн байна.

Эдийн засгийн энэ хурдацтай өсөлтийг хангах дэд бүтэц буюу эрчим хүч, дулаан, ус хангамжийн асуудлыг оновчтой, цаг алдахгүй шийдэх нь хотын, цаашлаад улсын хөгжилд шууд нөлөөтэй. Усны компактын хүрээнд Ус хангамжийн асуудлыг урьдчилан шийдвэрлэж байгаа гэдгийг онцлох нь зүйтэй...



Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэхийн ач холбогдлыг таниулна

Түрүүч нь 1-р нүүрт

Монголын Мянганы сорилтын сан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагааны ач холбогдлыг сурталчлан таниулах, мэдлэг, ойлголтыг түгээхэд Хэвлэлийн Хүрээлэнтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлээр мэргэшиж, сэтгүүл зүйн бүтээл туурвих сонирхолтой сэтгүүлчдийн багт зориулсан сургалтыг нэгдүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав.

Сургалтын үеэр Монголын Мянганы сорилтын сангаас хэрэгжүүлж буй төслүүд болон үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэхийн ач холбогдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэлээ.

ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Нидерландын ээлжит сургалтад 16 инженер, техникийн ажилтан хамрагдлаа



Мянганы сорилтын II Компакт гэрээгээр санхүүжүүлж буй Усны ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөр (WOP)-ийн хүрээнд Ус сувгийн удирдах газар (УСУГ)-ын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах зургаа дахь сургалтын аяллыг 2025 оны 1 дүгээр сарын 22-оос 2 дугаар сарын 1-нд Нидерландын Роттердам хот дахь Эвидес болон Хааг, Гоуда, Левдорп, болон Хьюберген хотын усны байгууллагуудад зохион

байгууллаа

Энэхүү зургаа дахь сургалтын аялалд оролцсон УСУГ-ын 16 инженер, техникийн ажилтан Нидерландын усны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, ахуйн болон үйлдвэрийн хаягдал усны цэвэрлэгээний технологи, горим, цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагаа болон тэдний ашигладаг автоматжуулалт, СКАДА системтэй гүнзгийрүүлэн танилцаж, тэргүүн туршлагаас нь суралцлаа.

Оролцогчид сургалтын үндсэн сэдвүүдээс гадна төслийн удирдлагын сургалтад хамрагдах, Нидерландын усны байгууллагууд, талбай, сайтаар зочилж, технологийн шинэчлэлүүдтэй танилцах зэргээр олж авсан үнэ цэнтэй мэдлэг, мэдээллийг бусдадаа хуваалцан байгууллагынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлж, Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын системийг сайжруулахаар төлөвлөгөө гарган танилцуулсан юм.

Улаанбаатар хотын УСУГ-ын хөрөнгийн менежментийг сайжруулах техникийн туслалцаа үзүүлнэ

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар (УСУГ) ОНӨААТҮГ-ын хөрөнгийн менежментийг сайжруулах техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний эхлэлийн уулзалт 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр боллоо.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд УСУГ-ын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хөрөнгийн менежментийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг хийж, үндсэн хөрөнгийн менежментийн урт

хугацааны төлөвлөгөө болон бодлогын баримт бичгийг боловсруулах юм. Мөн УСУГ-т хөрөнгийн менежментийн программ хангамж нэвтрүүлэхэд шаардлагатай туслалцааг үзүүлнэ.


Зөвлөх үйлчилгээг Франц улсын "Seuresca" инженерийн зөвлөх компани, дотоодын туслан гүйцэтгэгч "Престиж Инженеринг ХХК"-тай хамтран гүйцэтгэх юм. "Seuresca" компанийн зөвлөх үйлчилгээний багийн ахлагч бөгөөд хөрөнгийн удирдлагын зөвлөх мэргэжилтэн Арнауд Давид тус компанийн туршлага, техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын шат дараалал, аргачлал, УСУГ-ын үүрэг оролцоо, хүрэх үр дүнгийн талаар танилцууллаа.

Улаанбаатар хотын унд ахуйн усан дахь зэвийг арилгах төлөвлөгөө, зөвлөмж боловсруулна

"Улаанбаатар хотын унд ахуйн усан дахь зэвийг бууруулах урт хугацааны төлөвлөгөө, зөвлөмж" боловсруулах зөвлөхөөр шалгарсан Шинжлэх ухааны академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэн ажил эхлүүлэх уулзалтаа өргөн хүрээний оролцогч талуудыг хамруулан зохион байгууллаа.

Зөвлөх үйлчилгээний зорилго нь Улаанбаатар хотын унд ахуйн усанд зэв үүсэж буй шалтгаан, тохиолдол, хамрах хүрээ, үзүүлж буй нөлөөллийн талаар иж бүрэн суурь судалгаа хийх юм.

Үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэхтэй холбоотой цуврал вебинарыг зохион байгуулав



Түрүүч нь 1-р нүүрт

Энэхүү цуврал вебинарыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хүрээнд, Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан II Компакт гэрээний Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн санхүүжилтээр, “Үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэх гарын авлага боловсруулах” зөвлөх үйлчилгээний хүрээнд “Seureca Veolia” (Франц) болон “Евро Хан” ХХК-ийн түншлэл боловсруулаад байна.

Цувралын I хэсгийг төрийн байгууллагуудад, II хэсгийг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх үйл ажиллагаанд зориулан боловсруулжээ.

Улаанбаатар хотын унд ахуйн усан дахь зэвийг арилгах төлөвлөгөө, зөвлөмж боловсруулна

Түрүүч нь 4-р нүүрт

Судалгаанаас гарах зөвлөмжид үндэслэн зэвийг бууруулах, усны чанарыг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөөг боловсруулж, нийслэлийн удирдлага болон ус ашиглалтын байгууллагуудад хүлээлгэн өгөх юм.

Тус уулзалтад Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо, НЗДТГ, УБЗАА, УСУГ, ОСНААУГ, ОСК, СӨХ зэрэг нийт 12 байгууллагын 60 гаруй салбарын мэргэжилтэн, төлөөллүүд оролцож, санал зөвлөмж өглөө.

Монголын МСС-ийн төслийн гүйцэтгэгчид үндэсний аянд нэгдлээ



Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн гүйцэтгэгч Турк улсын “МАПА Иншаат” компани санаачлан Хүчирхийллийн

Цуврал - 1: Вебинарын сэдвүүд:

1. Үйлдвэрийн хаягдал усны бохирдлын ачааллыг тодорхойлох
2. Урьдчилан цэвэрлэгээний технологи нийлүүлэгчид
3. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны стандартын танилцуулга
4. Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх технологиуд, хэрэглээ

Цуврал - 2: Вебинарын сэдвүүд:

5. Сүү, бүүн бүтээгдэхүүний үйлдвэр
6. Согтууруулах ундаа ба ус, ундааны үйлдвэр
7. Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр
8. Талх, нарийн боовны үйлдвэр
9. Арьс шир боловсруулах үйлдвэр
10. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр
11. Хивс, даавуу, нэхмэлийн үйлдвэр
12. Хуванцар, нийлэг эдлэлийн үйлдвэр
13. Цаас, картон, цаасан хавтангийн үйлдвэр
14. Эмийн үйлдвэр
15. Химийн бодисын үйлдвэр
16. Бусад ангиллын үйлдвэр (Худалдаа, үйлчилгээ)



эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй байх ёстой. Шалтаг бүү тооч!” уриан дор хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлгээр хувийн хэвшлээсхөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд санаачилга гарган мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахын ач холбогдол, дэд бүтцийн төслийг жөндөрийн мэдрэмжтэй, зорилттой хэрэгжүүлэх сайн туршлага хуваалцав. Мөн олон улсад хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаар хэлэлцлээ.

Монголын Мянганы сорилтын сан АмЧам-ын гишүүн боллоо



Монголын Мянганы сорилтын сан нь Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам)-ын гишүүн боллоо. АмЧам Монгол нь дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар бөгөөд АНУ болон Монгол Улсын хооронд бизнесийн түншлэлийг бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах, Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм.

...

Монголын Мянганы сорилтын сан Монголын Бизнесийн зөвлөлд элслээ. Монгол Улсад худалдаа, бизнесийн орчныг сайжруулах, харилцааг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сар бүр бизнес эрхлэгчид, төр засгийн төлөөллүүдийг оролцуулсан уулзалт зохион байгуулдаг уламжлалтай юм.


Сонирхолтой тоо баримт:

Бүтээн байгуулалт эхэлснээс хойш:

6174	Хүнийг ажлын байраар хангасан
90%	Монголчууд
750	Эмэгтэй /12%/
1/3	СХД, ХУД, БГД-ийн иргэд
61.5 тэрбум.төг	ЖДҮ-ээс худалдан авсан бараа үйлчилгээ



Компакт гэрээ хэрэгжиж дуусахад



үлдлээ